


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

02.10 - 02.14



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт шинэ төлийн коронавирусын (Лхагва гарагт албан ёсоор COVID-19 гэж нэрлэв) тархалтыг хязгаарлаж чадна гэх хөрөнгө оруулагчдын хүлээлтээс үүдэн АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин нэг долоо хоног өсөлттэй хаагдлаа.

Зах зээлийн үнэлгээ өндөртэй индексүүд энэхүү хүлээлтээс үүдэн түүхэн дээд хэмжээнүүддээ хүрсэн ба Nasdaq Composite индекс технологийн компаниудын санхүүгийн үзүүлэлтүүд сайн байсантай холбоотой мөн түүхэн дээд хэмжээнд хүрчээ. S&P 500 индексийн сагсанд багтах үүрэн холбооны төвүүдийг ажиллуулдаг компаниудын хувьцаа өссөнтэй холбоотой жижиг үл хөдлөх хөрөнгийн салбар хамгийн их өсөлттэй байсан бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбарт хамгийн их бууралттай байлаа.

Холбооны нөөцийн сангийн (ХНС) Ерөнхийлөгч ноён Жером Пауэлл, COVID-2019-ийн тархалт дэлхийн эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг хэлэхэд “хэтэрхий эрт байна” гэсэн ч шинжээчид ойрын хугацаанд ХНС бодлогын хүүг бууруулна гэсэн хүлээлттэй байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд коронавирустай холбоотой айдас буурснаас үүдэн түүхэн дээд хэмжээ хүртлээ өссөн ч долоо хоногийн сүүлээр БНХАУ-д шинэ халдварын тоо огцом нэмэгдсэнтэй холбоотой өсөлт буурсан байна.

Их Британи улсын Ерөнхий Сайд ноён Борис Жонсон сангийн Канцлер ноён Сажид Жавидийг өөрийн зөвлөхүүдийг Их Британи улсын Засгийн газрын зөвлөхүүдээр соль хэмээн тушаасантай холбоотой ноён Сажид Жавид огцрох шийдвэр гаргасан байна. Төсвийг батлуулахаас гуравхан долоо хоногийн өмнө ноён Сажид Жавид ийнхүү огцорч байгаа нь санхүүгийн зах зээлд томоохон цохилт болсон ба шинжээчдийн үзэж байгаагаар түүний орлогч ноён Риши Сунак төсвийн зардлыг их хэмжээгээр нэмэгдүүлнэ гэсэн хүлээлттэй байгаа юм.

Япон: Амралтын өдөр таарсан энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага зэргийн бууралттай байлаа. Мягмар гарагт Япон улсын үүсгэн байгуулагдсан баярын өдрийн тохиосон тул Япон улсын хөрөнгийн зах зээл хаалттай байлаа.

Ихэнх эдийн засагчид Япон улсын эдийн засгийг 2019 онд 4%-аар буурсан гэсэн хүлээлттэй байсан ба энэхүү бууралт нь 10-р сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн НӨАТ-ийн нэмэгдэл, дэлхийн эдийн засгийн өсөлтийн бууралт болон далайн шуурга гэх мэт цаг уурын үзэгдлүүдтэй холбоотой юм.

БНХАУ: COVID-19-ийн тархалт хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байгаа ч БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд хөдөлгөөн багатай байлаа. Пүрэв гарагт коронавирусын халдвар авагсдын тоо огцом нэмэгдсэн ч хөрөнгийн зах зээлийн индексүүд бага хэмжээний бууралт үзүүлсэн байна. БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд ийнхүү өссөн нь дэлхийн эдийн засгийн үзүүлэлтүүд, АНУ-ын инфляц болон ажил эрхлэлтийн эерэг үзүүлэлтүүд болон БНХАУ-ын Ерөнхийлөгч ноён Ши Жиньпин коронавирусын тархалтыг зогсоох амлалттай холбоотой.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,983.30	1.31% ▲
Dow Jones	АНУ	29,398.08	1.02% ▲
S&P 500	АНУ	3,380.16	1.58% ▲
Nasdaq	АНУ	9,731.18	2.21% ▲
S&P/TSX	Канад	17,848.36	1.09% ▲
FTSE 100	Их Британи	7,409.13	-0.77% ▼
S&P/ASX 200	Австрали	7,130.20	1.53% ▲
Nikkei 225	Япон	23,687.59	-0.59% ▼
Hang Seng	Хонг Конг	27,815.60	1.50% ▲
Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	114.13
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.28
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.39
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	107.71
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.29
DBM' 2023	USD	7.250%	106.95
TDBM' 2020	USD	9.375%	101.12
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.94
Зах зээлийн хүү		Хаалт	Өөрчлөлт
Libor 1M		1.658	-0.01 ▼
Libor 3M		1.692	-0.04 ▼
Libor 6M		1.710	-0.03 ▼
Libor 1YR		1.798	-0.04 ▼
US 2YR Bond		1.428	0.04 ▲
US 3YR Bond		1.396	0.02 ▲
US 5YR Bond		1.416	0.03 ▲
US 10YR Bond		1.585	0.02 ▲
Валютын ханш		2020.02.14	Өөрчлөлт
USD		2,756.26	0.08% ▲
CNY		394.68	0.09% ▲
EUR		2,988.06	-1.06% ▼
RUB		43.44	0.35% ▲
KRW		2.33	0.43% ▲
JPY		25.11	0.20% ▲
CAD		2,080.27	0.50% ▲
Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,584.06	0.87% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	17.74	0.23% ▲
Зэс	USD/lb.	260.70	2.12% ▲
Нүүрс	USD/MT	70.93	0.97% ▲
WTI газрын тос	USD/bbl.	52.05	3.44% ▲
Brent газрын тос	USD/bbl.	57.32	5.23% ▲
Макро эдийн засгийн үзүүлэлтүүд		Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин		2019. XII	5.2%
Бодлогын хүү		2019. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү		2019. XII	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/		2019. XII	11.29%
Хадгаламжийн дундаж хүү /валют/		2019. XII	4.75%
Зээлийн дундаж хүү /төгрөг/		2019. XII	16.84%
Зээлийн дундаж хүү /валют/		2019. XII	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 41 компанийн 493.1 сая төгрөгийн 1,690,496 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол даатгал” /CHE/ компанийн хувьцаа 100.90%-аар буюу хамгийн ихээр өсөж 865.00 төгрөг хүрч хаагдсан бол “Монголын цахилгаан холбоо” /MCH/ компанийн хувьцаа 17.37%-аар буурч 58.60 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

02-р сарын 14-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,720.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,983.30 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.31%-аар өссөн байна.



Зах зээлийн тойм		Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн		493.1	
Зах зээлийн үнэлгээ		2,720,421.1	
Зах зээлийн индексүүд		Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20		18,983.30	1.31% ▲
MSE I индекс		9,338.49	0.02% ▲
MSE II индекс		7,702.55	-1.81% ▼
Идэвхтэй арилжагдсан хувьцаа		Ширхэг	Үнийн дүн
АПУ		456,276	281,123,306
Говь		124,799	31,875,092
Таван толгой		4,770	30,945,165
Лэндмн ББСБ		500,383	20,605,696
Улсын их дэлгүүр		12,968	15,130,082
Өсөлттэй хувьцаа		Хаалт	Өөрчлөлт
Монгол даатгал		865.00	100.90% ▲
Улсын их дэлгүүр		1,316.00	30.82% ▲
УБ-БҮК		345.00	15.00% ▲
Гермес центр		149.98	7.13% ▲
Жуулчин дюты фрий		92,800.00	2.93% ▲
Бууралттай хувьцаа		Хаалт	Өөрчлөлт
Монголын цахилгаан холбоо		390.00	-17.37% ▼
Багануур		910.00	-16.97% ▼
Стандарт проперти групп		49.00	-14.04% ▼
Адуун чулуун		1,220.00	-12.54% ▼
Ремикон		27.03	-9.87% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК		Дүн (төг)	
Би Ди Сек		552,711,390	
Стандарт Инвестмент		74,672,801	
Голомт Капитал		68,318,547	
Ард Секюритиз		65,571,139	
Ти Ди Би Капитал		35,530,509	
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани		Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ		622.75	662,719
Таван толгой		6,480.00	341,270
МИК Холдинг		14,940.00	309,397
Говь		257.18	200,629
Инвескор ББСБ		2,650.00	190,079

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01-р сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор "Баян-Алдар ББСБ" ХК-ийн оноосон нэрийг "Тандэм инвэст ББСБ" ХК болгон өөрчилж, нийтэд санал болгон гаргасан нийт 19,922,679 ширхэг энгийн хувьцааг 50 хувааж, 996,133,950 ширхэг энгийн хувьцаа болгон бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны III хуралдаан болж 21 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК (TSX:ERD; MSE:ERDN) нь 2019 оны 4-р улиралд Алтан Нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн хайгуул, өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцууллаа.
- "Инвескор ББСБ" ХК олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлангаа нийтэлсэн байна.
- "Монгол базальт" ХК олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлангаа нийтэлсэн байна.
- "Тандэм инвэст ББСБ" ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээлээ.



НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	ШИЙДВЭР ОГНОО	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	HRM	ГЕРМЕС ЦЕНТР ХК	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.05	2020.03.15-НД
2	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	1,103.6	331.1	30.0%	3.03	2020.02.13	2020.05.01-НЭЭС
3	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.03	2020.04.30-НЫ ДОТОР
4	HRD	ХҮРД ХК	722.5	72.4	10.0%	535.0	2020.02.17	2020.06.30-НЫ ДОТОР
5	NEH	ДАРХАН НЭХИЙ ХК	2,327.6	NA	NA	210.0	2020.01.31	2020.09.30-2020.12.30
6	BDS	БИ ДИ СЕК ХК	19.9	136.9	687.0%	10.0	2020.02.14	2020.12.31-НЫ ДОТОР
7	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ ХК	335.0	225.7	67.4%	4.0	2020.02.14	2020.06.29-НЫ ДОТОР
8	AIC	АРД ДААТГАЛ ХК	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.02.17	2020.06.30-НЫ ДОТОР

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Шинэ коронавирусийн тархалтын улмаас импортоор орж ирдэг түүхий эд, бараа материалын нөөцийн хомсдолт үүсэж байгаа нь дотоодын бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэл доголдоход хүргэж байгааг Улаанбаатар хотын худалдааны танхим мэдээллээ.
- ГЕГ: 1-р сард нийт импорт өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буурч, 473.3 сая ам.доллар болсон.



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг өгөх шийдвэр гаргасантай холбогдуулан 2020 оны 02-р сарын 17-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазар, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Баярсайхан болон Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нар мэдээлэл өглөө. Нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг хуваарилах бөгөөд 1,072 ширхэг хувьцаатай иргэнд 96,480 төгрөгийн ногдол ашиг олгогдох юм.

Компанийн тухай хуулийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан уг шийдвэрийг энэ оны 05-р сарын 01-ний дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны ногдол ашиг хуваарилах шинэ журмын дагуу 2020 онд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг олгох юм. Ингэхдээ иргэд хувьцааны дансаа баталгаажуулсан байх ёстой.



Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Тус хувьцаанд ногдох үнэ /₮/	Тус хувьцааг эзэмшиж буй иргэдийн тоо
527	47,130	10,844
536	48,240	28,160
741	66,690	334,519
750	67,500	667,898
848	76,320	41,359
857	77,130	131,256
955	85,950	9,393
964	86,760	34,491
1063	95,670	56,346
1072	96,480	1,080,592

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Алт олборлолтоор Австралид тэргүүлдэг “Newcrest Mining” компани санхүүгийн жилийн эхний хагаст ашиг нь 18%-р өсөж 280 сая ам.доллар хүрсэн гэж тайлагналаа. Алтны үнэ өсөлттэй байгаа учир биет олборлолт буурч, үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн ч гэсэн ашгийн үзүүлэлт сайн гарсан байна. Австралид байдаг Кадиа уурхайд засвар хийсэн, Папуа Шинэ Гвинейн Лихир уурхайд илүү үнэтэй түлш ашиглаж байгаа зэрэг шалтгаанаар компанийн зардал 18%-р нэмэгджээ. Ирээдүйд өсөлт авчирна гэж тооцоолон хэд хэдэн хөрөнгө оруулалт хийгээд байгаа учир энэ хагаст компанийн бэлэн мөнгөний урсгал сайжирна гэж харж байгаа юм байна.



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.